



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 07 сарын 28 өдөр

Дугаар 325

Улаанбаатар хот

“Эм пропертис рэйл эстэйт” ХХК-д хувьцаа эзэмшигчийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ын 4.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эм пропертис рэйл эстэйт” ХХК-д хувьцаа эзэмшигчийн бүтэц, бүрэлдэхүүнд хавсралтад заасны дагуу өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Хувьцаа эзэмшигчийн бүтэц, бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Эм пропертис рэйл эстэйт” ХХК /А.Солонго/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

• 151800000764